



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 116

Эрдэнэт

Хугацаа сунгах, үйл ажиллагаа зогсоох тухай

"Төр, сүм хийдийн харилцааны тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 1.1, "Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд шашны байгууллага байгуулж үйл ажиллагаа явуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Үйл ажиллагаа явуулах хугацаа дуусч, түүнийг сунгуулах тухай хүсэлт тавьж, холбогдох материалыг бүрдүүлж ирүүлсэн "Эрдэнэт бурханы сүм"-ийн үйл ажиллагаа явуулах хугацааг гурван жилээр сунгасугай.

2. Шашны байгууллагын үйл ажиллагаагаа түр зогсоохоор шийдвэрлэж, хүсэлт ирүүлсэн "Арьяадэва" шашны байгууллагын үйл ажиллагааг зогсоосугай.

ДАРГА  Т. ПҮРЭВЛХАГВА

